



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/015/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч: Я.Самбууням
Утас: Цахим хаяг: sambuunyamyia@audit.gov.mn
Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Отгонхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn
Аудитор: Г.Оюунтөгөлдөр
Утас: 261740 Цахим хаяг: Oyuntuguldurg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Н.УУГАНБАЯР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 01/1197
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гадаадын иргэн харьяатын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2024 оны 03 дугаар 13-ны өдрийн 107 дугаар тогтоолоор “Монгол Улсын виз олгох журам”-д өөрчлөлт оруулж, цахимаар 4 ангиллын виз олгож байсныг 64 ангилал болгон нэмэгдүүлснээр тайлант онд 77 улсын 92927 иргэнд цахим виз, 12027 иргэнд хилийн боомтод виз олгож, үндсэн бус үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 2,699.6 сая төгрөг болж, өмнөх оноос 2.0 дахин өссөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 160 дугаар тогтоолоор "Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан тушаалын ангилал зэрэглэл, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид албан ажлын, онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны мэргэшлийн зэргийн нэмэгдэл, нэмэгдлийн хэмжээ зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ыг шинэчлэн баталсан байна.

Бусад асуудал

Гадаад иргэнийг Монгол улсад урихаас эхлээд хилээр гарах хүртэлх хугацаанд 12-оос дээш удаа биечлэн ирж үйлчилгээ авдаг байсныг 2024 онд бүрэн цахимжуулж, immigration.gov.mn цахим хуудас шинэчлэгдэн, 5 хэлний сонголттой, энгийн хялбар болсон.

Цаасан хэлбэрээр олгож байсан визийн зөвшөөрлийг QR код бүхий цахим хэлбэрт шилжүүлж, "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" системд хандах эрхийг 32 элчин сайдын яам, 10 консулын газар, 4 төлөөлөгчийн газарт нээж өгснөөр нийт 50 Дипломат төлөөлөгчийн газрыг системд холбосон байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ

Я.САМБУУНЯМ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,307,986.2	4,331,881.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	68,834.8	68,126.2
33	АВЛАГА	0	1,192.9
34	УРЬДЧИЛГАА	29,410.8	40,116.5
35	БАРАА МАТЕРИАЛ	1,819,952.2	1,485,385.9
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	2,389,788.4	2,737,060.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,554,154.1	9,878,389.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,554,154.1	9,878,389.1
39200	Биет хөрөнгө	8,061,889.6	8,595,267.1
39300	Биет бус хөрөнгө	1,492,264.5	1,283,122.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,862,140.3	14,210,270.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	23,861.2	43,579.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	23,861.2	43,579.4
41300	Өглөг	3,820.0	23,514.1
41400	Урьдчилж орсон орлого	20,041.2	20,065.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,838,279.1	14,166,691.4
51	Засгийн газрын хувь оролцоо	13,838,279.1	14,166,691.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,433,292.5	1,455,792.5
51200	Хуримтлагдсан үр дүн	10,193,127.1	10,499,039.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,211,859.4	2,211,859.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,862,140.3	14,210,270.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	15,620,041.0	22,473,629.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,568,887.7	4,976,346.2
120	Нийтлэг татварын бус орлого	4,568,887.7	4,976,346.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,051,153.3	17,497,283.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,936,673.2	21,590,751.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,936,673.2	21,590,751.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,335,681.4	15,898,645.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,171,858.6	9,827,253.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	758,398.3	1,207,352.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	333,573.2	387,540.8
2104	Хангамж, бараа материалын зардал	521,746.8	456,063.9
2105	Нормативт зардал	-	1,177.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	125,125.8	321,688.9
2107	Томилолт, зочны зардал	82,293.3	95,813.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,098,157.8	2,032,174.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,244,527.6	1,569,580.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,600,991.9	5,692,106.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	2,683,367.7	882,877.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	752,350.8	454,501.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,931,016.9	428,376.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	17,015,172.7	28,489,967.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	5,010,858.3	8,270,543.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,010,858.3	8,270,543.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,010,858.3	8,270,543.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	953,161.1	2,722,140.7
120	Нийтлэг татварын бус орлого	953,161.1	2,722,140.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,051,153.3	17,497,283.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,871,838.6	27,800,391.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,871,838.6	27,800,391.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,285,689.5	13,851,877.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,171,759.0	9,828,256.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	758,023.3	1,207,352.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	330,788.6	420,795.4
2104	Хангамж, бараа материалын зардал	213,322.7	455,873.8
2105	Нормативт зардал	49,810.0	6,348.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	155,963.2	329,097.2
2107	Томилолт, зочны зардал	82,293.3	95,813.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	414,973.3	1,355,147.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,756.2	153,193.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,586,149.1	13,948,514.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,143,334.1	689,575.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,093,866.1	678,172.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,093,866.1	678,172.4
2200	Дотоод эх үүсвэрээр	1,093,866.1	678,172.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-1,093,866.1	-678,172.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-11,423.8	-12,111.7
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	11,423.8	12,111.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	38,044.3	-708.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	30,790.6	68,834.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	68,834.8	68,126.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,907,262.2	11,907,262.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	94,065.1	94,065.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,001,327.3	12,001,327.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-94,065.1	-94,065.1
9	Тайлант үеийн үр дүн	1,931,016.9	1,931,016.9
11	2023 оны 21-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,838,279.1	13,838,279.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-122,464.0	-122,464.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,715,815.1	13,715,815.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	22,500.0	22,500.0
19	Тайлант үеийн үр дүн	428,376.3	428,376.3
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,166,691.4	14,166,691.4

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,756,130,800.00	15,036,241,622.95	1,719,889,177.05	89.7
УРСГАЛ ЗАРДАЛ	16,332,330,800.00	14,688,969,814.28	1,643,360,985.72	89.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,638,690,800.00	14,015,340,670.28	1,623,350,129.72	89.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,936,628,400.00	9,762,372,574.41	1,174,255,825.59	89.3
Үндсэн цалин	5,268,257,700.00	5,011,022,577.96	257,235,122.04	95.1
Нэмэгдэл	2,839,666,900.00	2,501,901,679.10	337,765,220.90	88.1
Унаа хоолны хөнгөлөлт	1,755,415,000.00	1,637,812,534.32	117,602,465.68	93.3
Урамшуулал	1,073,288,800.00	611,635,783.03	461,653,016.97	57.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,442,566,000.00	1,201,035,972.74	241,530,027.26	83.3
Тэтгэврийн даатгал	980,944,800.00	819,199,889.62	161,744,910.38	83.5
Тэтгэмжийн даатгал	115,405,300.00	97,294,717.77	18,110,582.23	84.3
ҮОМШӨ-ний даатгал	57,702,500.00	49,044,305.36	8,658,194.64	85.0
Ажилгүйдлийн даатгал	57,702,800.00	47,431,745.92	10,271,054.08	82.2
Эрүүл мэндийн даатгал	230,810,600.00	188,065,314.07	42,745,285.93	81.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	492,151,900.00	420,795,433.41	71,356,466.59	85.5
Гэрэл, цахилгаан	95,238,200.00	72,887,824.04	22,350,375.96	76.5
Түлш, халаалт	148,529,900.00	133,968,101.71	14,561,798.29	90.2
Цэвэр, бохир ус	33,627,400.00	19,346,307.66	14,281,092.34	57.5
Байрны түрээс	214,756,400.00	194,593,200.00	20,163,200.00	90.6
Хангамж, бараа материалын зардал	473,073,300.00	455,873,833.44	17,199,466.56	96.4
Бичиг хэрэг	81,830,000.00	80,684,853.48	1,145,146.52	98.6
Тээвэр, шатахуун	232,383,800.00	229,970,089.50	2,413,710.50	99.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	45,730,000.00	35,242,369.46	10,487,630.54	77.1
Ном, хэвлэл	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	285,000.00	285,000.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	106,844,500.00	103,691,521.00	3,152,979.00	97.1
Нормативт зардал	8,808,800.00	6,348,400.00	2,460,400.00	72.1
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,022,200.00	1,953,400.00	68,800.00	96.6
Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,786,600.00	4,395,000.00	2,391,600.00	64.8
Эд хогшил, урсгал засварын зардал	617,643,000.00	599,293,643.00	18,349,357.00	97.0
Багаж, техник, хэрэгсэл	316,198,000.00	310,722,830.00	5,475,170.00	98.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	29,450,000.00	23,024,770.00	6,425,230.00	78.2

Урсгал засвар	271,995,000.00	265,546,043.00	6,448,957.00	97.6
Томилолт, зочны зардал	131,026,200.00	95,812,969.90	35,213,230.10	73.1
Гадаад албан томилолт	44,000,000.00	36,991,109.90	7,008,890.10	84.1
Дотоод албан томилолт	57,026,200.00	35,826,350.00	21,199,850.00	62.8
Зочин төлөөлөгч хүлээн авах	30,000,000.00	22,995,510.00	7,004,490.00	76.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,387,237,500.00	1,335,151,651.38	52,085,848.62	96.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	631,172,000.00	586,742,299.03	44,429,700.97	93.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	674,800.00	0.00	674,800.00	0.0
Даатгалын үйлчилгээ	114,898,200.00	111,831,846.35	3,066,353.65	97.3
Тээврийн хэрэгслийн татвар	4,965,000.00	4,044,076.00	920,924.00	81.5
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,100,700.00	817,000.00	283,700.00	74.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	108,214,300.00	107,479,020.00	735,280.00	99.3
Газрын төлбөр	5,332,500.00	3,935,660.00	1,396,840.00	73.8
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	520,880,000.00	520,301,750.00	578,250.00	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	149,555,700.00	138,656,192.00	10,899,508.00	92.7
Бараа үйлчилгээний бусад зардал	122,538,300.00	113,876,250.00	8,662,050.00	92.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,017,400.00	24,779,942.00	2,237,458.00	91.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	693,640,000.00	673,629,144.00	20,010,856.00	97.1
Бусад урсгал шилжүүлэг	693,640,000.00	673,629,144.00	20,010,856.00	97.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	29,256,200.00	28,986,200.00	270,000.00	99.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,368,600.00	37,367,856.00	744.00	100.0
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	358,937,900.00	342,425,088.00	16,512,812.00	95.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	268,077,300.00	264,850,000.00	3,227,300.00	98.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	423,800,000.00	347,271,808.67	76,528,191.33	81.9
Барилга байгууламж	423,800,000.00	347,271,808.67	76,528,191.33	81.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	16,756,130,800.00	15,036,241,622.95	1,719,889,177.05	89.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,306,130,800.00	12,336,605,139.70	3,969,525,660.30	75.7
Улсын төсвөөс санхүүжих	16,306,130,800.00	12,336,605,139.70	3,969,525,660.30	75.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	450,000,000.00	2,699,636,483.25	2,249,636,483.25	599.9
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	450,000,000.00	2,699,636,483.25	2,249,636,483.25	599.9
БАЙГУУЛЛАГЫН ТОО	640	564	76	88.1
Төсвийн байгууллага	8	8	0	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	316	278	38	88.0
Удирдах ажилтан	1	1	0	100.0

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,294,960,191.13
УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,294,960,191.13
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	156,500,701.04
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	65,883,518.94
Нэмэгдэл	-	12,936,158.35
Урамшуулал	-	52,947,360.59
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	6,316,945.10
Тэтгэврийн даатгал	-	4,216,115.34
Тэтгэмжийн даатгал	-	545,008.49
ҮОМШӨ-ний даатгал	-	338,160.09
Ажилгүйдлийн даатгал	-	188,729.73
Эрүүл мэндийн даатгал	-	1,028,931.45
Эд хогшил, урсгал засварын зардал	-	59,304,437.00
Багаж, техник, хэрэгсэл	-	19,998,000.00
Урсгал засвар	-	39,306,437.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	19,995,800.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	19,995,800.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,000,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,138,459,490.09
Бусад урсгал шилжүүлэг	-	1,118,453,290.09
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,118,453,290.09
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	20,006,200.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	20,006,200.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,294,960,191.13
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,294,960,191.13
ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	134,960,191.13
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,160,000,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 8 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 205.6 сая төгрөгийн 18 алдаа, зөрчил илэрснээс 163.8 сая төгрөгийн 5 алдаа¹ залруулж, 11.0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлэн, 30.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 8 зөвлөмжийг өгсөн байна.

Өмнөх оноос алдаа 6,006.1 сая төгрөгөөр, төлбөрийн акт 3.1 сая төгрөгөөр, албан шаардлага 21.6 сая төгрөгөөр, зөвлөмж 80.5 сая төгрөгөөр, нийт 6,111.3 сая төгрөгөөр буурсан байна.

Үүнээс төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 22.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 22.5 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

- *Улсын төсвийн хөрөнгө оруулалтын болон урсгал төсвийн худалдан авах ажиллагаанаас үүссэн барьцааг өглөгөөр бүртгэлгүй, барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого дансанд 22.5 сая төгрөгөөр бүртгэсэн.*

3.1 Албан шаардлага

Гадаадын иргэн, харьяатын газарт:

Илрүүлэлт 1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 667 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 112.6 сая төгрөгийн 5,000 м2 газар эзэмших эрхийг шилжүүлэн авч бүртгэсэн боловч газар эзэмших эрхийн гэрчилгээг аваагүй, өмнөх аудитын зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1-д “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгаагүй, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2. Өмнөх оны аудитаар өгсөн татварын цахим системийн тодорхойлолтоор 3,898.6 сая төгрөгийн өглөг, авлагын үлдэгдлийг 2024 оны жилийн эцсийн байдлаар 137.8 сая төгрөгийн илүү төлөлттэй, 128.1 сая төгрөгийн дутуу төлөлттэй болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зохион байгуулах, удирдах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгаагүй, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газар болон Гадаадын иргэн, харьяатын газарт:

Илрүүлэлт 1. Даталанд технологич ХХК-аас өдөр тутам ашигладаггүй, төсвийн нэгдсэн системийн программ хангамж /mojha.opengov.mn/-ийг 1 жилийн 4.0 сая төгрөгийн төлбөртэйгөөр худалдан авч, баталсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т үр ашигтай байх; 4.2.3.-т хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх; 4.2.7-д аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баталсан төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Гадаадын иргэн, харьяатын газарт:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1. ТӨБЗГ-ын 2024 оны ТӨБЗГ-ын 2024 оны "Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай" 679 дугаар тогтоол болон ТӨБЗГ-ын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн "Хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай" А-1/1642 дугаар албан бичигт тусгасан элэгдлийн дүн санхүүгийн тайлан дах дүнгээс 21.8 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дүнг үнэн зөв илэрхийлэх.

2. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт 2. Албан хаагчдад олгосон цалин, хөлс түүнтэй адилтгах орлогыг зөрүүтэй тооцоолсноос тайлант оны авлагыг 1.2 сая төгрөгөөр өр төлбөрийг 0.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажиллагчдад олгосон цалин, хөлс түүнтэй адилтгах орлогыг зөрүүтэй тооцоолж, авлага, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилгах.

ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газарт:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1. "Хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай" ТӨБЗГ-ын 2024 оны А-1/1642 дугаар албан бичгээр шилжиж ирсэн 5 нэр төрлийн 5 ширхэг хөрөнгийн дүн санхүүгийн тайлан дах дүнгээс 0.1 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дүнг үнэн зөв илэрхийлэх.

Гадаадын иргэн, харьяатын газрын төсвийн төвлөрүүлэн захирагчид:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1. Барилгын болон их засварын зураг төсвийг бүртгэх, хяналт тавих, зарцуулах асуудлыг байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Барилгын болон их засварын зураг төсвийг бүртгэх, хяналт тавих, зарцуулах асуудлыг өөрийн дотоод нөөц боломжид тулгуурлан нэмэлт зардал гаргахгүйгээр Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгах.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанд гарган ҮАГ-т ирүүлж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

4.1. Аудитаар нийт 163.8 сая төгрөгийн 5 алдаа³ илрүүлж, аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс: Залруулсан	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ГИХГ /ТТЗ/	1	22,504.2			1	22,504.2	1	22,504.2
2	ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газар	1	6,079.6			1	6,079.6	1	6,079.6
3	ГИХГ-ын Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	2	37,064.0			2	37,064.0	2	37,064.0
4	ГИХГ-ын Хойд бүс дэх газар	1	98,156.0	1	98,156.0			1	98,156.0
НИЙТ		5	163,803.8	1	98,156.0	4	65,647.8	5	163,803.8

4.2. Аудитаар нийт 41,799.8 сая төгрөгийн зөрчил⁴ илэрснээс 11.0 сая 5 албан шаардлага хүргүүлэн, 30.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 8 зөвлөмжийг өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ГИХГ /ТТЗ/	1	0.0			1	0.0
2	ГИХГ /аппарат/	6	27,220.0	3	4,000.0	3	23,220.0
3	ГИХГ-ын Агаарын замын боомт хариуцсан газар	2	4,147.3	1	4,000.0	1	147.3
4	ГИХГ-ын Баруун бүс дэх газар	1	0.0			1	0.0
5	ГИХГ-ын Хойд бүс дэх газар	1	0.0			1	0.0
6	ГИХГ-ын Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	2	10,432.5	1	2,974.0	1	7,458.0
НИЙТ		13	41,799.8	5	10,974.0	8	30,825.3

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх, тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн 1 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

4.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ГИХГ /аппарат/	1	-			1	-
	НИЙТ	1	-			1	-